# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН

# З А Х И Р А М Ж

2016 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр | Дугаар 6 | Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

1. Монгол Улс, Оросын Холбооны Улсын Нисэхийн эрэн хайх, авран туслах албадын хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулах Нисэхийн эрэн хайх, авран туслах үйл ажиллагааны олон улсын хамтарсан сургуулилалт (SAREX-2016)-ын бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ахлагч -Зам, тээврийн сайд

Гишүүд: -Эрүүл мэнд, спортын яамны Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

-Зам, тээврийн яамны Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга;

-Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга;

-Зэвсэгт хүчний Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлагч;

-Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга;

-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд дарга;

-Нислэг, техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дарга бөгөөд Ерөнхий шинжээч;

-Цагдаагийн ерөнхий газрын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын дарга;

-Зэвсэгт хүчний Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсийн дарга;

-Хил хамгаалах ерөнхий газрын Боомтын хамгаалалтын хэлтсийн дарга;

-Гааль, татварын ерөнхий газрын Буянт-Ухаа дахь гаалийн газрын дарга;

-Тагнуулын ерөнхий газрын ахлах ажилтан;

-Нислэг, техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ахлах шинжээч.

Нарийн бичгийн дарга -Иргэний нисэхийн ерөнхий газрын орлогч дарга бөгөөд Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт зохицуулалтын газрын дарга.

2. Олон улсын хамтарсан сургуулилалтын бэлтгэл ажлыг сайтар хангуулан зохион байгуулж, дүнг Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэгт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.САЙХАНБИЛЭГ

Зам, тээврийн сайд М.ЗОРИГТ